



"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр: **ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИИН УРВАЛЖ БОЛОН  
БУСАД ХЭРЭГЛЭГДЭХҮҮН**  
Тендер шалгаруулалтын дугаар: **ЭҮТӨҮГ/20240202981**



*authorized EMC-E*

## САНАМЖ

Тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл болох тул тендер шалгаруулалт зохион байгуулах, түүнд оролцохын өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, заавар, дүрэм, гэрээний нөхцөл, тендер шалгаруулалтын жишиг баримт бичигтэй сайтар танилцахыг зөвлөж байна.

Захиалагч нь тендер шалгаруулалт зохион байгуулахад худалдан авах ажиллагааны үндсэн зарчмууд болох өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтална.

Энэхүү харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолтын шаардлага, тендерийн жишиг маягт, гэрээний нөхцөл гэсэн бүлэгтэй.

Тендер шалгаруулалтын зааварчилгаа (цаашид “ТШЗ” гэх) бүлгийн зүйл, заалтыг нэмж, эсхүл өөрчилж үл болох бөгөөд захиалагч, оролцогч-сонирхогч этгээд нь тэдгээрийг баримтална. Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ТШЗ-нд үндэслэн, худалдан авах барааны онцлогийг харгалзан өгөгдлийн хүснэгт ( $\Theta X$ )-ийг боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн бэлтгэнэ.

Техникийн тодорхойлолт бүлэгт захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой хэрэгцээ, шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгасан байна.

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн тохирох мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ. Гэрээний нөхцөл бүлэг нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулагдах гэрээний зүйл, заалтууд тул талууд үүнийг судалсан байвал зохино.

Харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын анхаараах асуудлууд:

- ❖ Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Бараа цахим каталогт бүртгэгдсэн байна./
- ❖ Тендер шалгаруулалтын зарлал нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид урилга хүргүүлж, үнийн санал дуудна. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим систем [/www.tender.gov.mn/-д](http://www.tender.gov.mn/) нийтэлнэ.
- ❖ Үнийн саналыг дуудах хугацаа нь урилга хүргүүлсэн, зарлал нийтэлсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дараа байхаар тогтоосон байна.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно.
- ❖ Заасан хугацаанд сонирхогч этгээд тендерийг цахим системд ирүүлнэ.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагааг 2 хүртэл цагийн хугацаагаар зохион байгуулна. Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.
- ❖ Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.

Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол **удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.**



## **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА	5
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	12
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА	15
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ	19
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ	22



## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид “ӨХ” гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.

#### 2. Санхүүжилтийн үүсвэр

2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

#### 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

#### 4. Оролцогч, сонирхогч этгээдэд тавигдах өрөнхий шаардлага

3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

3.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 201, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.

4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.

4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр өрөнхий шаардлага хангасан байна.

4.3. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэх үүргийг гэрээнд заасан байна.

5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.



## **6. Бараанд тавигдах өрөнхий шаардлага**

5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

## **7. Худалдан авах ажиллагааны цахим систем**

6.1. Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан бараа худалдан авахаас, эсхүл хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд оролцогч аль ч улсын гарал үүсэлтэй бараа санал болгож болно.

## **8. Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл**

6.2. Харьцуулалтын аргаар худалдан авах бараа Сангийн сайдын баталсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу хуулийн 4.1.25-д заасан цахим каталогид бүртгэгдсэн байна.

7.1. Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

### **Б. АГУУЛГА**

## **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах**

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага, бараа нийлүүлэлтийн хуваарь;

IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;

V Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй.

8.3. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ -ы 10-д заасныг мөрдөнө.



**10. Тендер  
шалгаруулалтын баримт  
бичигт нэмэлт, өөрчлөлт  
оруулах**

10.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

10.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

10.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

**11. Тендер ирүүлэхийн  
өмнөх уулзалт**

11.1. Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.

11.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.

11.3. Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

**В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

**12. Тендер  
шалгаруулалтын хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцгчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13.1. Оролцгчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.1.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.1.2. Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.1.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.1.4. ТШЗ-ны 16-т заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;



- 13.1.5. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.1.6. санал болгож буй бараа ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.1.7. ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.1.8. ТШЗ-ны 22.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 14. Тендерийн жишиг маягт**
- 15. Хувилбарт санал**
- 16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**
- 17. Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл**
- 18. Санхүүгийн чадавхын шаардлага**
- 14.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
- 15.1. Хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг ирүүлэх шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 16.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.
- 16.2. Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг.
- 16.3. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
- 17.1. ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тавихад хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.
- 17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.
- 17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна..
- 17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.
- 18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагагаа ирүүлэхийг шаардахгүй.



- 19. Техникийн чадавх болон туршлагын шаардлага**
- 19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.
- 19.2.Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.3.Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 20. Санал болгож буй бараанд тавигдах шаардлага**
- 20.1.ТШЗ-ны 6.1-д заасан тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
- 20.2.Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод нийцсэн болохыг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.
- 20.3.Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно.
- 20.4.Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах бол түүнийг нотлох шаардлагатай.
- 21. Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ**
- 21.1.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой өгөгдлийн хүснэгтэд заасан бол дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үүнд:
- 21.1.1.санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, авах боломжтой хаяг, тэдгээрийн үнийн мэдээлэл;
- 21.1.2.засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл.
- 21.1.3.гадаадын этгээдийн хувьд нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт.
- 22. Тендерийн үнэ**
- 22.1.Унийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцгчийн тендерийн үнэ байна.
- 22.2.Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 22.3.Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.



- 22.4. Унийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 22.5. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцгчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

### **23. Тендерийн валют**

- 23.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.

### **24. Тендер хүчинтэй байх хугацаа**

- 24.1. Оролцгч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 24.2. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцгч өөрийн ТШЗ-ны 24.1-д заасан хугацааг сунгаж болно.
- 24.3. Оролцгч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.

## **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ**

### **25. Тендер баталгаажуулах, илгээх**

- 25.1. Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.
- 25.2. Оролцгчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.3. Оролцгч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.4. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

### **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

## **Д. УНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА**

### **27. Унийн санал дуудах хугацаа**

- 27.1. Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дотор эхэлнэ.
- 27.2. Унийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.



27.3.ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.

## **28. Тендер нээх**

28.1.ТШЗ-ны 27.3-т зааснаар хугацаа хаагдаад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч зөвхөн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.

## **Е. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ/ХЯНАН ҮЗЭХ**

### **29. Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх**

29.1.Нээсэн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.

29.2.Тендерт ирүүлсэн аливаа баримт бичгийн үнэн зөв, хүчинтэй байдлыг шалгаж үзэх эрхтэй байна.

29.3.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.

### **30. Тендерийн талаар тодруулга авах**

30.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.

## **Ё. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

### **31. Мэдэгдэл хүргүүлэх**

31.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

### **32. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

32.1.Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

32.2.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ.

32.3.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

## **Ж. БУСАД**

### **33. Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах**

33.1.Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг хуулийн 28.1.3-т заасан шийдвэрт заана.

33.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11 -д заасныг баримтална.

### **34. Тендер шалгаруулалтад гомдол гаргах**

34.1.Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.



## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХУСНЭГТ (ӨХ)

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	<p>Захиалагч: '<b>ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР</b>' ТӨҮГ          Тендер шалгаруулалтын нэр: Эмнэлгийн лабораторын урвалж болон бусад хэрэглэгдэхүүн          Тендер шалгаруулалтын дугаар: <b>ЭҮТӨҮГ/20240202981</b></p>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгө</b>
<b>ТШЗ 2.1</b>	Нийт төсөвт өртөг: <b>67,682,882</b> төгрөг
<b>Б. АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 9.2</b>	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> төрийн худалдан авах ажиллагааны цахим систем.          Хүлээн авагчийн нэр: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ          Утасны дугаар: 7575-9999, 7577-3504          Хаяг: Монгол Улс, Орхон аймаг Баян-Өндөр сум, Найрамдал талбай ш/х: 61027          Цахим шуудангийн хаяг: <a href="mailto:investdepartment@erdenetmc.mn">investdepartment@erdenetmc.mn</a>          Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоног байна. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдаалгүйгээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.</p>
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: " <b>Үгүй</b> "
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.2</b>	<p>Тендер шалгаруулалтын хэл:          Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер Монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг зохих ёсоор орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.  <b>Тендерийн материалыг Монгол хэл дээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>
<b>ТШЗ 12.4</b>	Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран орчуулга үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.



ТШЗ 16.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.</li> <li>2. Улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>3. Тендер шалгаруулалт зарласнаас хойшии өдрийн байдлаар Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх шаардлагатай.</li> </ol> <p><i>Жич: Улсын бүртгэлийн гэрчилгээ, татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр дамжуулан шалгана.</i></p> <ol style="list-style-type: none"> <li>4. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.</li> </ol> <p><i>Жич: Дээрх тодорхойлолтыг авах зааварчилгаатай <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системийн хэрэглэгчийн хөтөч үсэсээс танилцана уу.</i></p> <p><b>Хэрэв дээрх тодорхойлолтыг цахим системээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: "<b>Шаардана</b>"</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын борлуулалтын орлого нь он тус бүрт тендерт оролцгчийн санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй байна.</li> <li>2. Тендерт оролцогч нь 2021, 2022, 2023 он тус бүрт ашигтай ажилласан байна.</li> </ol>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: "<b>Тийм</b>"</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Оролцгчийн 2021, 2022, 2023 онуудын оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажсан байх шаардлагатай. Санхүүгийн тайлан цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерийн батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:  <ol style="list-style-type: none"> <li>2.1. Байгууллагын харилцагч банкин дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа,</li> <li>2.2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт,</li> </ol> <ol style="list-style-type: none"> <li>2.3. Үнэт цаас, Засгийн газрын бонд боон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.</li> </ol> <li>3. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшии өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн</li> </li></ol>



	<p>тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. Оролцогч “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a> хаягаар хандан авна.</p> <p>Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй. Жич: 2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр дамжуулан тендерт оролцогчдын баталгаажсан санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p>
<b>ТШЗ 19.1</b>	<p>Техникийн чадавх болон туршлага:<b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Оношуур тус бүрт Эрүүл мэндийн яамнаас баталсан оношуурын бүртгэлийн гэрчилгээг тендерт хавсаргаж ирүүлнэ. /Дуусах хугацаа 2026, 2027 он байна/</li> <li>- Оношуур тус бүрт үйлдвэрлэгчийн хэрэглэх зааварыг тендерт хавсаргаж ирүүлнэ.</li> </ul> <p>Ижил төстэй гэрээний туршлага:<b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. 2021, 2022, 2023 оны аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн байна.</li> <li>2. Ижил төстэй гэдэг Эмнэлгийн лабораторын урвалж болон бусад хэрэглэгдэхүүн нийлүүлж байсныг ойлгоно.</li> <li>3. Бараа нийлүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт (протокол эсхүл дүгнэлт эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг)-ын хуулбарыг нотариатаар гэрчлүүлж ирүүлнэ. (Хэрэв “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ - тай байгуулсан гэрээ бол нотариатаар батлуулах шаардахгүй).</li> <li>4. Оролцогч нь IV бүлгийн Маягт 2 “Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл”, Маягт 3 “Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл”, Маягт 4 “Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийн дагуу мэдээллийг бэлтгэн ирүүлнэ.</li> </ol>
<b>ТШЗ 19.3</b>	<p>Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх:<b>“Шаардахгүй”</b></p> <p>Тусгай зөвшөөрөл:<b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эм, эмнэлэгийн тоног төхөөрөмж, оношуур урвалж, ханган нийлүүлэх, импорлох, худалдаа, эмнэлэгийн хэрэгсэл нийлүүлэх, импортлох</li> <li>- Лабораторын оношлогоо, засвар үйлчилгээ</li> </ul> <p>тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь III бүлгийн “Бараа нийлүүлэлтийн хуваарь”-ийн 7 дугаар багана буюу нийлүүлэгчийн санал болгох хугацаа дуустал хүчинтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэр (PDF)-т шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай бөгөөд үншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.</li> <li>- Оролцогч нь III бүлгийн техникийн тодорхойлолт, бараа нийлүүлэлтийн хуваарийг бөглөж ирүүлэх.</li> <li>- Оролцогч нь барааны үнийн задаргааг бөглөж ирүүлнэ.</li> </ul> <p><b>ТӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>
<b>ТШЗ 22.2</b>	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>



<b>ТШЗ 22.3</b>	Олон улсын худалдааны нөхцөл: "Тийм" "Incoterms 2020", DDP- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах
-----------------	--

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

<b>ТШЗ 25.4</b>	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
<b>ТШЗ 26.1</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр</b> , Цаг: <b>09:00 цаг, минут</b>



authorized EMC-E

### **III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардлагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжссэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.



## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ 20.2-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

Барааны нэр: "ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРЫН УРВАЛЖ БОЛОН БУСАД ХЭРЭГЛЭГДЭХҮҮН" /Эсхүл түүнтэй дүйцэх/

Захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ уү.

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугцаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
...			



## БАГЦЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**БАГЦЫН НЭР:** Эмнэлгийн лабораторын урвалж болон бусад хэрэглэгдэхүүн

№	Сэлбэг, материалын нэр	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	HDL (high-density lipoprotein) их нягтралттай липопротейд /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 ш	Загвар: үйлдвэрлэгч-human LLC компани; Зориулалт: Цусанд их нягтралтай өөх тос тодорхойлох; Аппарат: Хумастар 200; Үйлдвэрлэгч: Хумастар компани; Хүчинтэй хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
2	Humastar 200 анализаторийн зүүний шахуурга /Эсхүл түүнтэй дүйцэх/	1 ш	Загвар: хумастар 200 усны шахуурга памп; зориулалт: биохимийн хумастар 200 анализаторийн усны шахуурга памп; тайлбар: техникийн үйлчилгээний дагуу 2 жил тутам солино; онцлог: анализатор нийлүүлсэн компаниас гэрээний дагуу худалдан авах;
3	Humastar 200 угаагч зүү /Эсхүл түүнтэй дүйцэх/	1 кор	Загвар: тусгай зориулалтын; тайлбар: биохимийн хумастар 200 анализаторт 2 жилд тутам солих заалттай; хэмжээ харагдах байдал: 5см хэмжээтэй ган зүү; онцлог: анализатор нийлүүлэгч компаниас гэрээний дагуу худалдан авах;
4	Humatsar 200 Halogen lamp /Эсхүл түүнтэй дүйцэх/	1 кор	Загвар: тусгай зориулалтын; зориулалт: биохимийн анализатор хэмжилт хийх; тайлбар: тус анализатор 1000 цаг ажиллаад ламп сольдог; онцлог: анализатор нийлүүлсэн компаниас гэрээний дагуу ;
5	low-density lipoprotein /бага нягтралттай липопротейд/ LDL /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 ш	Загвар: үйлдвэрлэгч - human LLC компани; Зориулалт: Цусанд бага нягтралтай өөх тос тодорхойлох; Аппарат: Хумастар 200; Үйлдвэрлэгч: Хумастар компани; Дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
6	sample cup /сорыцын хундага/2мл /Эсхүл түүнтэй дүйцэх/	1 ш	Загвар: HUMAN LLC; стандарт: iso 8655; багтаамж: 2мл; зориулалт: цусны шинжилгээний сорьц ялгах болон хяналтын материал таслаж хийх; материал: хуванцар; хэлбэр: хавтгай ёроолтой, таггүй, цлиндер хэлбэр бүхий хуванцар ; өнгө: тунгалаг доторхи зүйл нь нэвт харагдах; савалгаа: 1 уутандаа 1000ш тэй;
7	Автомат хөх пипетка /эмнэлгийн зориулалттай/	3 ш	Стандарт: ISO 8655; Багтаамж: 250 ul;

	/Эсхүл түүнтэй дүйцэх/		Ёроолын хэлбэр: Жижиг дугуй нүхтэй; Амсар: Үзүүрлүүгээ шовх нарийссан; Материал: Хуванцар; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх;
8	Автомат шар пипетка /эмнэлгийн зориулалттай/ /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 ш	Стандарт: ISO 8655; Багтаамж: 1000 ul; Ёроолын хэлбэр: Жижиг дугуй нүхтэй; Материал: Хуванцар; Амсар: үзүүрлүүгээ шовх нарийссан; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх;
9	Автоматическая пипетка 100-1000 хэмжээтэй /Эсхүл түүнтэй дүйцэх/	4 ш	Загвар: dragon med; зориулалт : Цус болон урвалжыг өндөр нарийвчлалтай хэмжээгээр хурдан зөв соруулах; хэмжээ: 100-1000мкл; Тусгай шаардлага: төрөл бүрийн халдвартгүйтгэл ариутгалд тэсвэртэй; Онцлог: хэрэглэхэд хурдан хялбар, дижитал дэлгэцтэй;
10	Автоматическая пипетка 20-200 хэмжээтэй /Эсхүл түүнтэй дүйцэх/	4 ш	Загвар: dragon med; зориулалт: цус болон урвалжыг өндөр нарийвчлалтай хэмжээгээр хурдан зөв соруулах; хэмжээ: 20-200мкл; тусгай шаардлага: төрөл бүрийн халдвартгүйтгэл, ариутгалд тэсвэртэй; онцлог: хэрэглэхэд хурдан хялбар, дижитал дэлгэцтэй;
11	Автоматическая пипетка 5-50 хэмжээтэй /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 ш	Загвар: dragon med; Зориулалт: цус болон урвалжыгөндөр нарийвчлалтай хэмжээгээр хурдан зөв соруулах; хэмжээ: 5-50мкл; тусгай шаардлага: төрөл бүрийн халдвартгүйтгэл ариутгалд тэсвэртэй; онцлог: хэрэглэхэд хурдан хялбар, дижитал дэлгэцтэй;
12	Биохимийн урвалж Альбумин 100млХ4 /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	альбумин: сийвэнгийн уургын фракц; альбумин : humastar 200 аппаратны уусмал ; хүн тун: 400; хэмжээ: 4x100 мл хэмжээтэй савлагаатай;
13	Биохимийн урвалж Амилаза 50млХ6 /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	зориулалт: цусан дахь амилаза ферментийн хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 50млх6; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй хугацаатай байх;
14	Биохимийн урвалж Ггтрансфераза 40млХ8,10млХ8 /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	зориулалт: цусанд гамма глутамил трансцераза фермент тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 40млх8, 10млх8; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
15	Биохимийн урвалж ГОТ /Эсхүл түүнтэй дүйцэх/	1 кор	зориулалт: цусанд аспартат аминотрансфераз фермент тодорхойлох;

			аппарат : хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 200млх4, 50млх4; хүчинтэй хугацаа: 2-3 жилийн хугацаатай байх;
16	Биохимийн урвалж ГПТ 200млХ4,50млХ4 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	1 кор	ГПТ: аланин трансаминааз /АЛАТ/; хэмжээ: 200млх4, 50млх4; аппарат : хумастар 200 тохиорх; хугацаа: хүчинтэй хугацаа урт байх; зориулалт: цусан дахь АЛАТ фермент тодорхойлох;
17	Биохимийн урвалж Кальци 50млХ2 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	2 кор	зориулалт : цусанд калцийн хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 100млх2, ; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
18	Биохимийн урвалж креатинин 50млХ2,100млХ2 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	4 кор	зориулалт : цусанд креатинины хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 100млх2, 50млх1; дуусах хугацаа: 2-3 жилийн хугацаатай байх;
19	Биохимийн урвалж ЛДГ 40млХ8,10млХ8 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	2 кор	зориулалт : цусанд лактатдегидрогеназа фермент тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 40млх8, 10млх8; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
20	Биохимийн урвалж магни 100млХ2 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	2 кор	зориулалт : цусанд магнийн хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 100млх2; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
21	Биохимийн урвалж мочевин 40млХ8,10млХ8 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	2 кор	зориулалт : цусанд мочевиний хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 40млх8, 10млх8; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй хугацаатай байх;
22	Биохимийн урвалж нийт уураг 100млХ4 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	3 кор	зориулалт: цусан дахь уургийн хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 100млх4; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй хугацаатай байх;
23	Биохимийн урвалж сахар 100млХ4 <i>/Эсхүл түүнтэй дүйцэх/</i>	3 кор	зориулалт: цусанд сахарын хэмжээг тодорхойлох уусмал; аппарат : хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани;

			хэмжээ: 100млх4; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
24	Биохимийн урвалж төмөр 20млХ2,5млХ2 /Эсхүл түүнтэй дүйцэх/	4 кор	зориулалт: цусанд төмрийн хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 20млх2, 5млх2; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
25	Биохимийн урвалж триглицерид 100млХ4 /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	зориулалт: цусан дахь триглицеридийн хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 100млх4; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
26	Биохимийн урвалж фосфор 100млХ2 /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 кор	зориулалт: цусан фосфорын хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 100млх4; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
27	Биохимийн урвалж холестириин 100млХ4 /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	зориулалт: цусан дахь холестрины хэмжээг тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 100млх4; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
28	БИОХИМИЙН УРВАЛЖ ШУУД БИЛИРУБИН /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	Загвар: Хумастар; зориулалт: цусанд шууд билирубиний хэмжээ тодорхойлох; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 100мл*3 75мл*1; хугацаа: 1-2 жилийн хүчинтэй хугацаатай байх;
29	Биохимийн урвалж шүлтлэг фосфатаза 20млХ5 /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 кор	зориулалт: цусанд шүлтлэг фосфатаза тодорхойлох уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 40млх8, 10млх8; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
30	Биохимийн урвалж шээсний хүчил 30млХ4 /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	зориулалт: цусан дахь шээсний хүчлийн хэмжээг тодорхойлох; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 30млх4; дуусах хугацаа: 1-2 жилийн хугацаатай байх;
31	ВАКУТАЙНЕР ГЕЛЬ 5мл /Эсхүл түүнтэй дүйцэх/	2000 ш	Загвар: Шар тагтай /биохими-иммунологи/; зориулалт: цусны шинжилгээнд сорьц цуглуулахад хэрэглэнэ; материал: шар өнгийн тагтай, ёроолдоо гельтэй

			ваакуум шил; тусгай шаардлага: цус бүлэгнэлтийг зогсоох уусмал, ийлдэс тусгаарлагч гельтэй ; хугацаа: 2-3 жилийн хүчинтэй хугацаатай;
32	грамын будаг /эмэгтэйчүүдийн мазокын шинжилгээний сорьц будах/ /Эсхүл түүнтэй дүйцэх/	1 ш	Загвар: himedia; зориулалт: мазокын шинжилгээний сорьц будах; иж бүрдэл дотор байх уусмалууд: 100-125мл хэмжээ бүхий 4 төрлийн иж бүрдэл /Grams Crystal Violet. Iodine. Safranin. Decolourizer ; Үйлдвэрлэгч: Himedia компани; Хугацаа: 3-5 жилээс дээш хүчинтэй хугацаатай байх;
33	Кали /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 ш	Загвар: үйлдвэрлэгч-Human LLC; Зориулалт: Цусанд кали хэмжээ тодорхойлох; Аппарат: Хумастар 200; Үйлдвэрлэгч: Хумастар компани; Хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
34	КУВЕЙТ CHEM WELL №500, 2 МЛ /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 ш	стандарт : iso 8655; багтаамж : 1,5мл; зориулалт : цусний шинжилгээний сорьц ялгах, хяналтын материал хадгалах, өөрөөсөө тагтай байх; материал: хуванцар; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх; хэлбэр: 1,5мл хэмжээтэй таглаатай, хуванцар материалтай, ; ёроол: цилиндр; өнгө: өнгөгүй /доторх материал харагдах, тунгалагдуу/;
35	Натри /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 ш	Загвар: үйлдвэрлэгч-human LLC; Зориулалт: Цусанд натри хэмжээ тодорхойлох; Аппарат: Хумастар 200; Үйлдвэрлэгч: Хумастар компани; Дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
36	Нийт билирубиний урвалж 100млХ3 75млХ1 Auotobilirubin D /Эсхүл түүнтэй дүйцэх/	4 кор	Зориулалт: Цусанд нийт билирубин тодорхойлох; Аппарат : Хумастар 200; Үйлдвэрлэгч: Хуман компани; хэмжээ: 100мл*3 75мл*1; хугацаа: 1-2 жилийн хүчинтэй хугацаатай байх;
37	Сорьц цуглуулах шилэн сав 2мл /Эсхүл түүнтэй дүйцэх/	3000 ш	зориулалт : шинжилгээний сорьц цуглуулах, ЭДТА уусмалтай байх; стандарт : iso13485; хэмжээ: 3мл , 8 см өндөртэй, бар кодтой байх; материал : шилэн, ягаан өнгийн резинэн тагтай байх ; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх;
38	Сорьц цуглуулах шилэн сав 5мл /Эсхүл түүнтэй дүйцэх/	4000 ш	Эмнэлэгийн улаан тагтай: Шинжилгээний сорьц авхад хэрэглэнэ; материал : шилэн, улаан өнгийн резинэн тагтай байх; стандарт : iso13485; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх; хэмжээ : 5мл, өндөр 11,5см байх, бар кодтой байх;

39	СоЭ /улаан эсийн тунах хурд/ шил /Эсхүл түүнтэй дүйцэх/	2400 ш	зориулалт: цусны улаан эсийн тунах хурд тодорхойлох; материал харагдах байдал: Хар өнгийн резин тагтай ваакуум шил; тусгай шаардлага: 3.5% эсвэл 3.8% sodium citrate уусмалтай 1.28мл хэмжээтэй 11.5 см өндөр нарийхан, бар кодтой; хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх;
40	СоЭ /улаан эсийн тунах хурд/ шилний суурь /Эсхүл түүнтэй дүйцэх/	5 ш	зориулалт: цусны улаан эсийн тунах хурд тодорхойлох; Материал харагдах байдал: пластик материалтай, цагаан өнгөтэй, 1суурьт 10ш соэ ваакуум шил тогтоох багтаамжтай ; тусгай шаардлага: 5нэгжийн нарийвчлал бүхий 0-150 хүртэл тоотой зураасан хэмжээс бүхий; онцлог: бүх төрлийн ариутгал халдвартгүйтгэлд тэсвэртэй хэмжээс арилхааргүй байх;
41	Урвалж Humatrol N 5млХ6 /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 кор	зориулалт: биохимийн аппаратий хяналтын уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 5млх6; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
42	Урвалж Humatrol P 5млХ6 /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 кор	зориулалт: биохимийн аппаратны хяналтын уусмал; аппарат : хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 5млх6; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
43	Урвалж serodos Plus 5млХ6 /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 кор	зориулалт: биохимийн аппаратны хяналтын уусмал; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 5млх6; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
44	Урвалж wash additive 25млХ4 /Эсхүл түүнтэй дүйцэх/	1 кор	зориулалт : биохимийн аппаратны угаагч уусмал; аппарат : хумастар 200; үйлдвэрлэгч: хуман компани; хэмжээ: 25млх4; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх;
45	Урвалж wash solution 30млХ12 /Эсхүл түүнтэй дүйцэх/	8 кор	зориулалт: биохимийн аппаратны угаагч уусмал; аппарат : хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 30млх12; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй байх;
46	Урвалж автокал 5млХ6 Autocal /Эсхүл түүнтэй дүйцэх/	3 кор	зориулалт : биохимийн аппаратны тохируулагч уусмал /калибратор/; аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 5млх6; дуусах хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
47	Урвалж липаза 10млХ4, 5млХ2	5 ш	зориулалт : цусан дахь липаза фермент тодорхойлох;

	/Эсхүл түүнтэй дүйцэх/		аппарат: хумастар 200; үйлдвэрлэгч : хуман компани; хэмжээ: 10млх4, 5млх2; дуусах хугацаа: 2-3 жилийн хүчинтэй хугацаатай байх;
48	Хеликобактерийн хурдавчилсан оношлуур 1X25 H-PYLORI /Cassete/ /Эсхүл түүнтэй дүйцэх/	10 ш	сүүлийн үеийнх: 2023 оноос хойш;
49	Цусны бүлэг тодорхойлох уусмал /anti A/ /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 ш	Загвар: dialab; зориулалт: цусны бүлэг, резус тохироо тодорхойлох; үйлдвэрлэгч: DIALAB компани; хэмжээ: 10мл; онцлог: дусаагууртай пипетка бүхий тагтай шилн бортогтой; хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
50	Цусны бүлэг тодорхойлох уусмал /anti B/ /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 ш	Загвар: dialab; зориулалт: цусны бүлэг, резус тохироо тодорхойлох; үйлдвэрлэгч: Dialab компани; хэмжээ: 10мл; онцлог: дусаагууртай пипетка бүхий тагтай шилэн бортогтой; хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;
51	Цусны бүлэг тодорхойлох уусмал /anti D/ /Эсхүл түүнтэй дүйцэх/	2 ш	Загвар: dialab; зориулалт: цусны бүлэг, резус тохироо тодорхойлох; үйлдвэрлэгч: Dialab компани; хэмжээ: 10мл; онцлог: дусаагууртай пипетка бүхий тагтай шилэн бортогтой; хугацаа: 1-2 жилийн хүчинтэй байх;

## Бараа нийлүүлэлтийн хуваарь

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	HDL (high-density lipoprotein) их нягтралттай липопротейд	3	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
2	Humastar 200 анализаторийн з??ний шахуурга	1	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
3	Humastar 200 угаагч з??	1	KOP	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
4	Humatsar 200 Halogen lamp	1	KOP	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
5	low-density lipoprotein /бага нягтралттай липопротейд/ LDL	3	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
6	sample cup /сорьцын хундага/2мл	1	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
7	Автомат хөх пипетка /эмнэлгийн зориулалттай/	3	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
8	Автомат шар пипетка /эмнэлгийн зориулалттай/	3	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
9	Автоматическая пипетка 100-1000 хэмжээтэй	4	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
10	Автоматическая пипетка 20-200 хэмжээтэй	4	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
11	Автоматическая пипетка 5-50 хэмжээтэй	2	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
12	Биохимийн урвалж Альбумин 100млX4	3	KOP	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
13	Биохимийн урвалж Амилаза 50млX6	3	KOP	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
14	Биохимийн урвалж Ггтрансфераза 40млX8,10млX8	3	KOP	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
15	Биохимийн урвалж ГОТ	1	KOP	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	



authorized EMC-E

16	Биохимийн урвалж ГПТ 200млХ4,50млХ4	1	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
17	Биохимийн урвалж Кальци 50млХ2	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
18	Биохимийн урвалж креатинин 50млХ2,100млХ2	4	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
19	Биохимийн урвалж ЛДГ 40млХ8,10млХ8	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
20	Биохимийн урвалж магни 100млХ2	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
21	Биохимийн урвалж мочевин 40млХ8,10млХ8	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
22	Биохимийн урвалж нийт уураг 100млХ4	3	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
23	Биохимийн урвалж сахар 100млХ4	3	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
24	Биохимийн урвалж тэмер 20млХ2,5млХ2	4	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
25	Биохимийн урвалж триглициерид 100млХ4	3	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
26	Биохимийн урвалж фосфор 100млХ2	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
27	Биохимийн урвалж холестирин 100млХ4	3	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
28	Биохимийн урвалж шүлтлэг фосфатаза 20млХ5	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
29	БИОХИМИЙН УРВАЛЖ ШУУД БИЛИРУБИН	3	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
30	Биохимийн урвалж шээсний хүчил 30млХ4	3	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
31	ВАКУТАЙНЕР ГЕЛЬ 5мл	2000	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
32	грамын будаг /эмэгтэйч??дийн мазокын шинжилгээний сорьц будах/	1	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
33	Кали	2	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
34	КУВЕЙТ CHEM WELL №500, 2 МЛ	3	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	



authorized EMC-E

35	Натри	2	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
36	Нийт билирубиний урвалж 100млХ3 75млХ1 Autobilirubin D	4	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
37	Сорьц цуглуулах шилэн сав 2мл	3000	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
38	Сорьц цуглуулах шилэн сав 5мл	4000	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
39	СоЭ /улаан эсийн тунах хурд/ шил	2400	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
40	СоЭ /улаан эсийн тунах хурд/ шилний суурь	5	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
41	Урвалж Humatrol N 5млХ6	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
42	Урвалж Humatrol P 5млХ6	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
43	Урвалж serodos Plus 5млХ6	2	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
44	Урвалж wash additive 25млХ4	1	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
45	Урвалж wash solution 30млХ12	8	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
46	Урвалж автокал 5млХ6 Autocal	3	КОР	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
47	Урвалж липаза 10млХ4, 5млХ2	5	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
48	Хеликобактерийн хурдавчилсан оношлуур 1Х25 H-PYLORI /Cassete/	10	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
49	Цусны бүлэг тодорхойлох уусмал /anti A/	2	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
50	Цусны бүлэг тодорхойлох уусмал /anti B/	2	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
51	Цусны бүлэг тодорхойлох уусмал /anti D/	2	Ш	DDP "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногт нийлүүлнэ.	
	Нийт	11531				



#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД**

Маягт 1	Тендер илгээх маягт .....	20
Маягт 2	Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл	21
Маягт 3	Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	21
Маягт 4	Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	21
Маягт 5	Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт	21



**[Захиалагч байгууллагын нэр]-д**

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэ дугаар]** тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон нээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 3.1. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээнээс хойш **[30 ба түүнээс дээши хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна<sup>1</sup>
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догодолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг мэдээлэл:**



## Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

## Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

## Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

## Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		



4.			
5.			



## V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч ЭЦЭСЛЭНЭ.



## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

### Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
  - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
  - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
  - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
  - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
  - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;



- 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

## Гэрээний тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
  - 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
  - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
  - 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
  - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
  - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ



- Бараа нийлүүлэх**
- 2.1. Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
  - 2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
  - 2.3. ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
  - 2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
  - 2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
  - 2.6. Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуварийг үндэслэн ГТН-д заана.
  - 2.7. Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
    - 2.7.1. Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэгүй;
    - 2.7.2. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
  - 2.8. Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
  - 2.9. ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
  - 2.10. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
  - 2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
  - 2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
  - 2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.



- |                           |  |
|---------------------------|--|
| <b>Баглаа боодол</b>      | <p>2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ.</p> <p>2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.</p> <p>2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.</p> <p>2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.</p> <p>2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарь дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p>  |
| <b>Худалдааны нөхцөл</b>  | <b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b>  |
| <b>Барааг хүлээн авах</b> | <p>3.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p>  |
| <b>Шалгалт, туршилт</b>   | <p>3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.</p> <p>3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p> <p>3.7. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохироулга хийх эсэх, тохироулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.</p> |
| <b>Гэрээний үнэ</b>       |  |



## Төлбөр төлөх

- 3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

### Захиалагчийн хүлээх эрсдэл

- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна.

4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.

4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.

4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.



4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.

4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.

4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.

4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.

4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.

4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хулээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.

### **Чанарын баталгаа**

### **Алданги**

### **Оюуны өмчийн эрх зөрчих**



**Гэнэтийн буюу  
давагдашгүй хүчний  
шинжтэй онцгой нөхцөл  
байдал**

**Үүрэг гүйцэтгэх нэмэлт  
хугацаа**

**Гэрээнээс татгалзах,  
гэрээг цуцлах үндэслэл**

- 4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
- 4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

**ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ**

- 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
  - 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;
  - 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;
  - 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.
  - 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.
- 5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.



- 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
- 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
- 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

#### **Төлөөлөгч**

- 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
- 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
- 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

#### **Туслан гүйцэтгэгч**

- 6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.

#### **Нууцлал**

- 6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

#### **Мэдэгдэл**

- 6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.



- 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:
- 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;
- 6.15.2. үнийн тохируулга хийсэн.
- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

### **Маргаан шийдвэрлэх**



## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: <b>DDP - "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах</b>
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: <b>Бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу</b>
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: <b>Incoterms 2020, DDP-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах</b> Бараанд холбогдох баримт бичиг: <b>Чанарын сертификат, техникийн тодорхойлолт</b> Угсралт, суурилуулах: <b>Шаардахгүй</b>
ГЕН 2.14.	Худалдааны нөхцөл: <b>Incoterms 2020, DDP-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах</b>
ГЕН 2.16.	Баглаа боодол түүний дотор гадна талд тэмдэглэгээ хийх
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: <b>Incoterms 2020, DDP-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах</b>
ГЕН 3.8.	Үнийн тохируулга хийх аргачлал
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: <b>Бараа нийлүүлж, гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш 30 хоногт</b>
ГЕН 4.2.	Даатгал
ГЕН 4.10.	Чанарын баталгаат хугацаа: <b>12 сар</b>
ГЕН 4.11.	Чанарын баталгаа: <b>Шаардахгүй</b>
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: <b>"Тийм"</b> Алдангийн хувь: <b>хоног тутамд 0.1% ба алдангийн нийт дүн нийт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.</b>
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: <b>"Тийм"</b> Алдангийн хувь: <b>хоног тутамд 0.1% ба алдангийн нийт дүн нийт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.</b>



## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэр] гэрээ  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид "нийлүүлэгч" гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Бараа" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Техникийн тодорхойлолт;
  - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

- 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА



## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: 2024-05-14

Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**

Тендер шалгаруулалтын нэр: Эмнэлгийн лабораторын урвалж болон бусад хэрэглэгдэхүүн

Тендер шалгаруулалтын дугаар: **ЭҮТӨҮГ/20240202981**

Нийт төсөвт өртөг: **67,682,882**

Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

1. "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: "*Үгүй*"
3. Унийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: "*Унийн санал дуудах ажиллагааг хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоо хамгийн багадаа нэг байна.*"
4. Унийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: "*Унийн санал дуудах журам*"
5. Унийн санал дуудах ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 09:10 цаг, минутад эхлүүлж, 2 хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 09:00 цаг, минутаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 09:10 цаг, минутад нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: "*Зөвшөөрөхгүй*"
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: "*Эрхгүй*"
9. Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

